

МОНГОЛ ДАХЬ ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫН АСУУДАЛ

Х.Батхүү

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын тэнхимийн докторант

С.Базарпүрэв

МУИС, ШУС, Нийгмийн ухааны салбар,
Улс төр судлалын зөвлөх профессор

Хураангуй:

Хууль тогтоох эрх мэдэл, түүний нэг чухал бүрдэл хэсэг нь парламентын хяналтын асуудал байдаг бөгөөд түүнийг хэрэгжүүлж буй байдал нь тухайн улсынхаа засаглалын хэлбэр, эдийн засаг, ардчиллын түвшин зэргээс хамаарч янз бүрийн арга, хэлбэртэй хэрэгжиж байна. Парламент нь гүйцэтгэх эрх мэдлийн институтдээ хяналт тавих нь төрийн эрх мэдэл хуваарилах онолын харилцан хянах зарчимд үндэслэсэн, түүнд нийцсэн байдаг. Тиймээс тус өгүүлэлд Монгол дахь парламентын хяналтын өнөөгийн байдал, түүнийг хэрэгжүүлж байгаа хэлбэр, арга хэрэгслүүдийг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин, боломж, улс төрийн нөхцөлийг судлан гаргасан. Парламентын хяналтын үр нөлөөг дээшлүүлж, арга механизмыг боловсронгуй болгох нь парламентын автономи байдал, парламентын ардчилалд чухал нөлөөтэй юм.

Түлхүүр үг: хууль тогтоох эрх мэдэл, парламент, хяналт, сөрөг хүчин

Удиртгал:

Английн философич Жон Стюарт Милль “төлөөллийн ардчилалд парламент нь “ард түмний нүд, чих, дуу хоолой” гээд төрийн энэхүү институтийн гол зорилт нь засгийн газрыг хянах, түүний аливаа үйлдэл, үйл ажиллагааг хэлэлцэж, алдаа дутагдлыг нь буруушааж зэмлэх явдал бөгөөд ард иргэдийн гомдол саналыг авч үзэх, санал бодлоо илэрхийлэх газар байх ёстой гэж үзсэн байна.¹

Хууль тогтоох эрх мэдэл нь Үндсэн хууль хийгээд нийтээр дагаж мөрдөх хуулийг тогтоох, улсын төсөв батлах, түүнчлэн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих эрхийн цогц юм². Ардчилсан нийгэмд хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгч гол институт нь парламент байдаг. Парламент нь хууль тогтоох, нийт ард түмний эрх ашгийг илэрхийлж, тэднийг төлөөлөх үндсэн хоёр шинжтэй. Энэ хүрээнд ард түмнийг төлөөлөх чиг үүрэгтэй нь холбон парламентын хяналтыг тайлбарласан байна³. Жишээлбэл, “...Ардчилсан нийгэмд төрийн дээд эрхийг иргэдийн төлөөлөгчид гартаа барьж байх ёстой бөгөөд парламентын хяналтаас гадуур төрийн ямар ч салбар байх ёсгүй юм...” гэжээ. Харин доктор Д.Лүндээжанцан парламентын хяналт шалгалтыг түүний хууль тогтоох үйл ажиллагаатай холбон тайлбарлажээ.⁴

¹ Ж.Төртогтох “Үндсэн хуулийн политологийн шинжилгээ” УБ., 2010 он, 62 дахь тал

² Д.Лүндээжанцан “Эрх мэдэл ба ардчилал” УБ., 2015, 18 дахь тал

³ П.Амаржаргал “Үндсэн хуулийн эрх зүй Парламентын онол үзэл баримтлалын асуудал” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл., 2015, 115 дахь тал

⁴ П.Амаржаргал “Үндсэн хуулийн эрх зүй Парламентын онол үзэл баримтлалын асуудал” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл., 2015, 116 дахь тал

Эрх мэдэл болон мөнгө Засгийн газарт ихээхэн төвлөрч, парламентын лидерүүд гүйцэтгэх засаглалд орж ажиллах болсон, гүйцэтгэх засаглалын оролцооны түвшин нэмэгдэж парламентад нөлөөлөхүйц түвшинд хүрсэн зэрэг нь “парламентын уналт”-ын шалтгаан болох болсон. Ийм нөхцөлд парламентын хяналтыг хэрэгжүүлэх сонирхолгүй байх, хяналт үгүй болох аюултай. Хэдий тийм ч засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох зэрэг нь хууль тогтоох эрх мэдлийн бүрдэл хэсэг болохын зэрэгцээ парламентын үндсэн үүрэг, түүний бүтэц, үйл ажиллагаанд нэвт шингэж, төрийн эрх мэдлийн мөчир хоорондын хяналт, тэнцлийн зарчмыг хэрэгжүүлэх механизм, гүйцэтгэх эрх мэдэлд өгөх улс төрийн үнэлэмж, хууль, бодлогын гажуудлыг арилгах гол хэрэгсэл, арга болдог.

Парламентын хяналт)Parliamentary oversight, Legislative oversight, parliamentary control(гэдэг нь парламентаас Засгийн газрын үйл ажиллагаанд тавих бүхий л талын төлөвшсөн бүхэл бүтэн хяналтын тогтолцоо бөгөөд хууль, тогтоомж, төсвийн бодлого, түүний хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх үнэлэлт дүгнэлт өгөх, шаардлагатай арга хэмжээ авах, хариуцлага тооцох үндсэн механизм⁵ бөгөөд дараах ач холбогдолтой⁶. Үүнд:

- Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн салаа, мөчир хоорондыг харилцан тэнцвэржүүлэх (check and balance)

- Парламентын автономит байдлыг хангах, гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус байх боломжийг нэмэгдүүлэх

- Төрийн ил тод, нээлттэй байдлын нэг чухал хөшүүрэг, арга зам болдог

- Гүйцэтгэх засаглалыг залах, чиглүүлэх механизм болно

- Хариуцлага бол ардчилсан засаглалын суурь шинж болдог

- Гүйцэтгэх эрх мэдлийн тодорхой бодлого, үйл ажиллагаа олон нийтээр хэлэлцэгдэх, үнэлэгдэх боломж бий болно

Орчин үеийн төрийн байгуулалд парламентад ёс нь гурван чухал үнэт зүйл бий болгосон⁷.

1. Хууль тогтоох үйл ажиллагааг ард түмний төлөөлөлтэй нэгтгэсэн. Өөрөөр хэлбэл дарангуйлагч дангаар захирах ёсыг халж, ард түмний төлөөллөөр хууль тогтоох болсон

2. Төрийн эрх мэдлийг гурван салаанд хуваарилж хэрэгжүүлэх, хяналт, тэнцэлтэй хүнд ээлтэй тогтолцоог бий болгосон

3. Парламент нь хөгжлийг зогсоогч, саатуулагч бус харин туурвин бүтээгч байхад шилжсэн

Төрийн эрх мэдэл хуваарилах онолын нэгээхэн амин сүнс нь харилцан хяналтын механизм бөгөөд тэр дундаа парламентын хяналтын асуудал чухлаар тавигддаг. Энэхүү сэдэв нь ардчилал, парламентад ёс, засаглал хуваарилах зарчим, парламентын өөрийнх нь судалгааны хөгжилд практик ач холбогдлоороо чухал бөгөөд нийт ард түмний улс төрийн эрх ашиг, төлөөллийн ардчиллын үнэт зүйлстэй салшгүй холбоотой гэж үзэж байна. Монтескьегийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үзэл санааг нэг талаас ардчилсан нийгэм, Үндсэн хуулийг бүтээх үзэл баримтлалын цэгцтэй тулгуур онол, нөгөө талаас ардчилсан төрийн байгууллыг зохион байгуулах Үндсэн хуулийн зайлшгүй мөрдлөг болгох суурь шаардлага, норматив болж байдаг

⁵ Улсын Их Хурлын Тамгын газар “Бодлогын судалгаа, шинжилгээ” XII боть, УБ., 2012

⁶ Х.Номингэрэл “Парламентын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх механизм, бусад орнуудын жишиг, Монгол Улсын Их Хурлын хяналтын чиг үүргийг боловсронгуй болгох асуудал”, “Байнгын ажиллагаатай Парламент 25 жил” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл УБ., 2015, 23 дахь тал

⁷ Б.Чимид “Парламентын хяналт, шалгалтыг төгөлдөржүүлэх нь” илтгэл УБ., 2010

үндсэн зарчим гэж үздэг. Иймээс түүнийг судлаачид онол төдийгүй зарчим хэмээдэг⁸. Төрийн эрх мэдэл хуваарилах онолын амин сүнс, зарчмыг дараах гурван хүчин зүйлээр тодорхойлж болох юм⁹.

1. Эрх мэдлийг зааглан хуваарилах. Аливаа төр нь нэг л засаглалтай байх бөгөөд түүнийг хуваадаггүй харин эрхлэх ажил буюу чиг үүргийг нь засаглалын гурван салаанд хуваарилж хэрэгжүүлэх нь зохистой. Энэ тухай Ж.Локк засаглалыг хууль тогтоох, гүйцэтгэх (үүндээ шүүхийг хамруулсан), холбооны (гадаадад хэрэгжүүлэх гүйцэтгэх эрх мэдэл) гэж ангилсан¹⁰, бол Монтескье эрх чөлөөг бодитой хэрэгжүүлэхийн тулд төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн гурван төрөлд хэрэгжүүлбэл зохистой гэж үзсэн.
2. Эрх мэдлийг харилцан тэнцвэржүүлэх. Төрийн эрх мэдлийг дээрх засаглалын гурван салаа, мөчирт зааглан хуваарилж, тэдгээрийн хоорондын үйл ажиллагаа, зохион байгуулалтын харилцан шүтэлцээтэй байдлыг хангаж, тэнцвэржүүлэх ёстой. Энэ нь тэдгээрийн гүйцэтгэх эрх үүрэг, мөн чанартай холбоотой юм. Тухайлбал, Ж.Локк хууль тогтоох засаглал “бусдад зориулсан хууль гаргах” чадвар нь “дээгүүр байх шаардлагатай” учраас тэргүүлж байх ёстой гэж үзсэн¹¹. Харин Ш.Л.Монтескье хууль тогтоох байгууллага бүх ард түмэнд харьяалагдаж, ард олон өөрсдийн эс үйлдэж чадах зүйлээ төлөөлөгчдөөрөө дамжуулан гүйцэтгүүлж, тэнд өөр өөр эрх ашгийг илэрхийлж байдаг гэсэн байна.
3. Эрх мэдлийг харилцан хянах. Ж.Локк парламентад онцгой ач холбогдол өгч хэрэв хуулийг үл ойшоох, зөрчих тохиолдолд гүйцэтгэх эрх мэдэлдээ хариуцлага тооцох санаа тусгасан бөгөөд гүйцэтгэх эрх мэдэл нь парламентын хүсэл зоригийн дагуу өөрчлөгдөж, солигдож болно гэсэн. Эндээс парламент гүйцэтгэх эрх мэдлээ хянах, хариуцлага тооцох бүрэн эрхтэй бөгөөд энэ эрхээ ард олноос авсан гэсэн агуулга харагдана. Энэхүү зарчим Монтескьегийн үзэл баримтлалд илүүтэйгээр тусгалаа олсон байдаг. Түүний үзсэнээр засаглалын салаа мөчрүүд хоорондоо нягт уялдаа хамааралтай байж чиг үүргээ харилцан хуваарилсан, эрх мэдэл тус бүртээ харьцангуй автономн буюу бие даасан байж, харилцан тэнцвэртэй, хяналт тавьсан байхыг чухалчлаад засаглалын салаа мөчрүүд харилцан чиг үүргээ хуваарилж, тэнцвэртэй, хяналт тавьж ажиллахыг анхааруулсан байдаг¹²:

Дээрхээс хууль тогтоох эрх мэдлийн байгууллага гүйцэтгэх эрх мэдлийн институтдээ хяналт тавих нь төрийн эрх мэдэл хуваарилах онолын амин сүнс болох харилцан хянах зарчимд үндэслэсэн байдаг бөгөөд хуулийн хэрэгжилтийг хянах, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагыг томилох, огцруулах, хариуцлага тооцох зэрэг асуудлуудыг хууль тогтоох эрх мэдэл гэдэгт багтаан ойлгох нь зүйтэй юм.

Парламентын хяналтыг хэрэгжүүлж байгаа олон улсын практик

Хариуцлага, ил тод байдалгүй ардчилсан парламентын систем гэж байдаггүй. Парламент нийт ард түмний өмнөөс хяналтын үүргээрээ дамжуулан гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагааг хянах, чиглүүлэх, хариуцлага тооцох, нийтийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бодлого боловсруулан баталж мөрдүүлдэг. Өдгөө дэлхий даяар улсуудын парламент маш олон арга замаар хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж байна. Энэ талаар Хиронори Ямамото 88 улсыг харьцуулан судалгаа хийж парламентын хяналтын гол үйл ажиллагааг дараах байдлаар авч үзсэн байна¹³. Үүнд:

⁸ Д.Болд-Эрдэнэ “Улс төрийн философи” УБ., 2015, 343 дахь тал

⁹ Д.Болд-Эрдэнэ “Улс төрийн философи” УБ., 2015, 343 дахь тал

¹⁰ Ж.Төртогтох “Үндсэн хуулийн политологийн шинжилгээ” УБ., 2010, 54 дахь тал

¹¹ Х.Ганбаатар нарын “Өрнөдийн улс төрийн сэтгэлгээний түүх” УБ., 2009, 24 дахь тал

¹² Шарль Моньескье “Хуулийн амин сүнс”, 148 дахь тал

¹³ Hironori Yamamoto “Tools of parliamentary oversight” Switzerland., 2007 /IPU/

- Засгийн газрын хууль бус үйл ажиллагаа, эрх мэдлээ урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх, дур зоргоороо авирлах зэрэг байдлыг илрүүлэх, сэргийлэх
- Татвар төлөгчдийн мөнгө санхүүг зарцуулж буй байдлыг хянах, хариуцлага тооцох
- Засгийн газрын мэдээлэл болон парламентаар зөвшөөрсөн хууль, тогтоомжийг батлах. Энэ нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр, хуулийн хүрээнд тавьсан зорилтуудын хэрэгжилтэд мониторинг хийх
- Засгийн газрын ил тод байдлыг нэмэгдүүлэх, олон нийтийн Засгийн газарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх

Тэрээр судалгаандаа парламентын хороодын хяналт, танхимын хяналт, омбудсмэний хяналт гэсэн гурван ерөнхий хэсэгт парламентын хяналтыг ангилан судалсан. Омбудсмэн нь парламентын хяналтын институтэжсэн хэлбэр байдаг бол хороод болон танхимын хяналт нь функциональ хэлбэр буюу парламентын өөрийнх нь үндсэн чиг үүрэгт шингэсэн байдаг гэж үзжээ.

Парламентын хороодын хяналт: Энэ нь тухайлсан чиглэл асуудлыг хариуцан хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг үндсэн бүтцийн нэгж байдаг. Хороод нь засгийн үйл ажиллагаанд дангаар хяналт тавих, хуулийн төслийг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, тухайлсан асуудлаар бие даан шийдвэр гаргах эрхтэй байдаг. Тухайлбал, тусгай асуудлаар мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж болдог. Энэ нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын нийтийн эрх ашгийг хохироосон, улс төрийн шинж чанартай хууль бус үйл ажиллагааг шалгах зорилготой байдаг.¹⁴

Парламентын танхимын хяналт: Засгийн газрын мэдээлэл сонсох, асуулга, асуулт тавих, Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх тухай санал хураалт, Засгийн газрыг огцруулах зэрэг хяналтын арга хэрэгслийг хамааруулан ойлгож болно. Тухайлбал, Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх тухай санал хураалт нь парламентын хяналтын нэг арга хэрэгсэл болдог бөгөөд энэхүү конструктив саналын журмыг тусгасан анхны үндсэн хууль нь ХБНГУ-ын 1949 оны үндсэн хууль билээ.¹⁵ Агуулга нь Засгийн газарт итгэл үл хүлээлгэх санал дэвшүүлэхдээ холбооны Канцлерын албан тушаалд нэр дэвшигчийг нэгэн зэрэг дэвшүүлдэг. Ингэснээр Засгийн газарт итгэл хүлээлгэх эсэх асуудлаарх санал хураалт нь нэгэн зэрэг шинэ холбооны канцлерын сонгууль болдог байна.

Омбудсмэн: Парламентын хяналтыг хэрэгжүүлдэг институтэжсэн хэлбэр бол омбудсмэн юм. Өөрөөр хэлбэл гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа, алдаа зөрчилтэй холбогдох иргэдийн гомдлыг хариуцдаг институт юм. Омбудсмэнийг парламент сонгох буюу парламенттай зөвшилцөн төрийн тэргүүн томилдог бөгөөд ажлын тайлангаа парламентад тавьдаг. Өдгөө дэлхийн 50 гаруй улсад энэхүү тогтолцоог хэрэгжүүлж байна.

Рикардо Пелиззо, Рик Штапенхорст нар “Парламентын хяналтын эмпирик судалгаа” бүтээлдээ 88 улсын парламентын хяналтын асуудлыг дараах гурван хувьсагчаар шинжлэн үзэж хоорондын харилцан хамаарлыг тогтоосон байна.¹⁶

1. Улсуудын засаглалын хэлбэр. Парламентын хяналтын хэрэгсэл ба үр нөлөө нь засаглалын хэлбэрээс ихээхэн хамаардаг. Ерөнхийлөгчийн засаглалын хэлбэрт парламентын хороодод, парламентын засаглалын хэлбэрт парламентын цөөнхөд түшиглэсэн нь их байна. Ерөнхийлөгчийн засаглалын хэлбэрт парламентын олонх өөр намаас сонгогдсон бол хяналт ширүүн байж, заримдаа бие биенээ гацаах нөхцөл үүсдэг бол парламентын засаглалд олонх ба хамтарсан засгаас шалтгаалан хяналт сулрах, олонхоороо давамгайлах боломжтой гэж үзжээ.

¹⁴ Улсын Их Хурлын Тамгын газрын судалгааны төв “Бодлогын судалгаа шинжилгээ” УБ., XII боть, 2012

¹⁵ Ч.Энхбаатар, С.Зульфикар “Гадаад орнуудын төрийн байгуулалт” УБ., 2014, 177 дахь тал

¹⁶ Ricardo Pelizzo and Rick Stapenhurst “Tools for Legislative Oversight: An Empirical Investigation” 2007

2. Орлогын түвшин. Улсуудын орлогын түвшин буурах тутам парламентын сонсгол, хяналтыг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь багасч, асуулга, асуултын арга хэрэгслийг ашиглах нь орлогын түвшин өгсөх тутам нэмэгддэг гэж үзсэн байна. Харин омбудсмэний хувьд бага орлоготой улсуудын хувьд ашиглах нь 50% хүртэл багасаж байгааг судалгааны дүнгээрээ харуулжээ.

3. Ардчиллын түвшин. Судалгаанд хамрагдсан улсуудын парламентын хяналтын арга хэрэгслийн тоо, хэлбэр нь тухайн орныхоо ардчиллын түвшингээс хамаарч илүү ардчилсан орнуудад парламентын хяналтын арга, хэрэгслийн тоо, хэлбэр нь нэмэгдэн сайжирч байна гэжээ.

4.

Монгол дахь парламентын хяналт, түүнийг хэрэгжүүлэх боломж

Төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл тэдгээрийг хэрэгжүүлэх арга, хэлбэр, эрх хэмжээ нийтлэг ба онцлог шинж, хоорондынх нь харилцаанд баримтлах зарчим, үндсэн чиглэл зэргийг Монгол улсын Үндсэн хуулиар тогтоосон.

Монгол улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд “ Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална” гэж заасан байдаг. Тодруулж хэлбэл, Улсын Их Хурал нь тус орны дээд жолоодлогын гол зангилаа, төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тогтоож, нийгмийн дээд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бөгөөд түүний онц бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг батлах өөрчлөх асуудал хамаарна¹⁷. Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд: “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах”, “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах” зэргийг Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамааруулсан. Б.Чимид асан “Онцгой бүрэн эрх гэдэг бол ач холбогдолтой онцгой гэдэг ач холбогдолтой үг. Энэ бол бусад байгууллага шийддэггүй асуудлыг хэнтэй ч хуваалцдаггүй нь онцгой гэж байгаа юм гэсэн. Эндээс үзвэл Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг өөр бусад байгууллагад даалган хэрэгжүүлэх боломжгүй юм.¹⁸ Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд: “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” гэж заасан нь Монгол дахь парламентын хяналтын асуудлыг судлах суурь үндэс болж байгаа юм.

Хууль тогтоох эрх мэдэл дан ганц хууль санаачлах хийгээд батлах хүрээгээр хязгаарлагдахгүй бөгөөд Засгийн газрыг бүрдүүлэх болон бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах, Засгийн газар болон төрийн бусад байгууллагуудын үйл ажиллагааг хянах (асуулга асуух, буруушаасан тогтоол гаргах, үл итгэхээ илэрхийлэх, сайд нарыг чөлөөлөх, Засгийн газрыг огцруулах зэрэг хэлбэрээр хэрэгжинэ) зэрэг бүрэн эрхүүдийг багтаасан ойлголт юм.¹⁹ Өөрөөр хэлбэл парламентын хяналт нь хууль тогтоох үйл ажиллагааны үндсэн агуулга, үүрэг болох юм. Үүнийг хураангуйлбал, хууль тогтоох үйл ажиллагаа=хууль гаргах+биелэлтийг хянаж, шалгах хоёрын нийлбэр гэж бүдүүвчилж болно²⁰ гэжээ.

Парламентын засаглалтай улсын парламентыг үндсэндээ хязгааргүй бүрэн эрхтэй төрөлд хамааруулж үздэг бөгөөд үүнд дараах эрх хамаарна:

- Хууль тогтоох эрх гагцхүү парламентад байдаг
- Улсын төсвийг баталж, татвар тогтоодог

¹⁷ Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар “Монгол улсын Үндсэн хуулийн эрх зүй” УБ., 2000, 147 дахь тал

¹⁸ П.Амаржаргал “Үндсэн хуулийн эрх зүй Парламентын онол үзэл баримтлалын асуудал” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл., 2015, 114 дэх тал

¹⁹ Д.Лүндээжанцан “Эрх мэдэл ба ардчила” УБ., 2015, 18 дахь тал

²⁰ Б.Чимид “Парламентын хяналт, шалгалтыг төгөлдөржүүлэх нь” илтгэл УБ., 2010

- Засгийн газар нь парламентад тайлагнаж, ажлаа хариуцдаг
- Шүүгчдийг баталдаг

- Хяналтын чиг үүрэг гүйцэтгэдэг. Энэ бүх шинж манай Улсын Их Хуралд бий²¹.

Манайд Үндсэн хуулиар парламентын хяналт шалгалт хийх бүрэн эрхийг ерөнхий байдлаар тодорхойлсон боловч хуульчлан тодорхойлсноос үзвэл Улсын Их Хурлын хяналт шалгалтын объект нь Засгийн газар болон Улсын Их Хурлаас томилогдсон, түүнд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын үйл ажиллагаа байна²². Харин парламентын хяналтыг хэрэгжүүлэгч субъект нь парламент өөрөө бөгөөд түүнийг дараах байдлаар ангилан үзэж болох юм. Үүнд:

- Улсын Их Хурлын гишүүн: Монтескье “Хуулийн амин сүнс” бүтээлдээ: “...ард олон өөрсдийн эс үйлдэж чадах зүйлээ төлөөлөгчдөөрөө дамжуулан гүйцэтгүүлдэг байх шаардлагатай” гэжээ. Манай Үндсэн хуулийн 23 дугаар зүйлд “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж заасан. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын гишүүн нь нийт иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлэгч болохын хувьд парламентын хяналтыг хэрэгжүүлэгч субъект болох юм.
- Байнгын болон дэд, түр хороод: Парламентын бүтэц, зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь байнгын болон дэд хороод байдаг бөгөөд Улсын Их Хурал энэхүү бүтцээрээ дамжуулан хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх боломжтой. Энэ тухай Үндсэн хуулийн 28 дугаар зүйлд “...Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавьбал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэж туссан.
- Гишүүдийн бүлэг буюу ажлын хэсэг: Улсын Их Хурал, байнгын болон дэд, түр хорооноос байгуулагдсан ажлын хэсэг буюу “гишүүдийн бүлэг” хэлбэрээр байж болно. Мөн УИХ дахь намын бүлгийг хамааруулна.
- Улсын Их Хурал: Парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд гол объект нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага байдаг ба энэ нь ихэнхдээ улс төрийн шинжтэй хяналт юм.²³ Өөрөөр хэлбэл Засгийн газар үйл ажиллагааныхаа төлөө нийт ард түмний төлөөллийн байгууллага парламентын өмнө улс төрийн хариуцлага хүлээдэг. Манай Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 6, 8 дахь хэсгүүдэд энэ тухай тусгасан.

Монгол дахь парламентын хяналтын хэлбэр, арга хэрэгсэл: Парламент хяналтын чиг үүрэг, хариуцлага тооцох механизмаа хэрхэн хэрэгжүүлэхээс хууль тогтоох эрх мэдлийн автономит байдал, гүйцэтгэх засаглалын чанар, дэг журам цаашлаад төрийн шударга, ил тод хариуцлагатай байдал, хууль, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх ардчиллын үнэт зүйлс хамаарах нь дамжиггүй. Үүний тулд парламент уг үүргээ хэрэгжүүлэх сонирхол, хүсэл эрмэлзэлтэй байж, түүнийг биелүүлэх сайн тогтолцоо, арга механизмыг бүрдүүлэх нь чухал юм. Улсын Их Хурал дараах хэлбэрээр хяналтаа хэрэгжүүлж байна. Үүнд:

- Засгийн газрын үйл ажиллагааны тайлан мэдээлэл сонсох, хэлэлцэх: Энэ нь хууль, бусад шийдвэрийн хэрэгжилтийн байдал, цаг үеийн мэдээллийг чуулганы хуралдаанаар сонсох, үнэлэлт, дүгнэлт өгөх зэрэг сайн талтай ч зөвхөн мэдээлж, сонсох төдийхнөөр хязгаарлагддаг сул талтай.

²¹ Б.Дэлгэрмаа “Парламентын засаглал, хууль тогтоох бүрэн эрх ба УИХ” “Шинэ толь сэтгүүл” УБ., 1999

²² П.Амаржаргал “Үндсэн хуулийн эрх зүй Парламентын онол үзэл баримтлалын асуудал” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл., 2015, 117 дахь тал

²³ Б.Дэлгэрмаа “Парламентын засаглал, хууль тогтоох бүрэн эрх ба УИХ” “Шинэ толь сэтгүүл” УБ., 1999

- Асуулга, асуулт тавих: Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүдэд асуулга, асуулт тавих, түүний хариуг нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх. Энэ нь нэлээн түгээмэл хяналтын хэлбэр юм. Асуулга, асуулт хоёр нь хоорондоо зарчмын ялгаатай байдаг.
- Байнгын хороодоор дамжуулан хяналт тавих: Энэ нь тодорхой нийгмийн бодлогын салбар хариуцсан байнгын хороод хяналтын чиг үүргийг гүйцэтгэж байгаа хэлбэр бөгөөд түгээмэл арга, хэлбэрт тооцогдоно.
- Тусгайлсан байнгын хяналтын хороодоор хэлэлцүүлэх, дүгнэлт гаргах: Энэ нь байнгын хорооны дэргэд тусгайлсан хяналтын дэд хороодыг байгуулж тодорхой асуудлаар үнэлэлт, дүгнэлт өгөх хэлбэр юм. Тухайлбал, төсвийн байнгын хорооны дэргэд төсвийн зарлагын дэд хороо, хууль зүйн байнгын хорооны дэргэд хүний эрхийн дэд хороо зэргийг ажиллуулж, парламент дахь цөөнхийн гишүүнээр даргалуулах, шууд хяналт хийх эрхийг олгосноороо ихээхэн давуу талтай байна.
- Итгэл үзүүлэх эсэх тухай санал хураах: Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлд “Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал...” Улсын Их Хурал шийдвэрлэхээр заасан боловч Засгийн газрын өөрийнх нь бүрэн эрхийн хүрээнд хамааруулсан байдаг. Энэ тухай зарим судлаачид “конструктив механизмыг манай Үндсэн хуульд авч хэрэглээгүй байна... конструктив механизм суулгаагүйн улмаас Ерөнхий сайдыг огцруулах, шинэ Ерөнхий сайдыг сонгох хооронд хугацаа алдаж гүйцэтгэх эрх мэдлийн тасралтгүй байдал алдагдаж байсан гашуун туршлага манайд бий. Тухайлбал, 1998 онд Ц.Элбэгдоржийн засгийн газар огцорч, шинэ ерөнхий сайдаа томилж чадалгүй удсаар зургаан сар болсон тохиолдол бий”²⁴ гэсэн байна.
- Засгийн газрыг огцруулах: Парламентын өмнө Засгийн газар үйл ажиллагааныхаа төлөө улс төрийн хариуцлага хүлээдэг ба энэ талаар манай Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд: “Ерөнхий сайд хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах” гэж туссан.

Улсын Их Хурал парламентын хяналтыг хэрэгжүүлэхдээ мэдээлэл сонсох, хэлэлцэх, асуулга, асуулт тавих, байнгын хороо болон дэд, түр хороод дээр сонголт хийх, хариуцлага тооцох зэрэг арга хэрэгслийг ашиглаж байна. Ер нь парламентын хяналтын арга хэрэгсэл ба үр нөлөө нь тухайн улсын засаглалын хэлбэр, улс төрийн соёл, улс төрийн намын төлөвшил зэрэг олон хүчин зүйлээс хамаарна. Парламент дахь олонх ба цөөнхийн хүчний харьцаа Улсын Их Хурал, Засгийн газрын харилцааг тодорхойлно. Өөрөөр хэлбэл цөөнх, сөрөг хүчинд эрх мэдэл илүү олгох замаар хяналтыг хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй байдаг.

Монголд шинэ Үндсэн хууль батлагдан, ардчилсан засаглал, парламентат ёс төлөвшиж эхэлснээс хойш даруй 30 жил өнгөрч, найм дахь үеийн парламентын нүүрийг үзэж байна. Энэ хугацаанд парламентын хяналт түүнийг хэрэгжүүлэх хэлбэр, арга хэрэгслүүдийг тодорхой хэмжээнд тодорхойлж, эрх зүйн орчин боломжийн түвшинд бүрдсэн байгаа ч түүнийг хэрэгжүүлэх улс төрийн сонирхол, хүсэл эрмэлзэл хангалтгүй байсаар байна. Судлаачид Улсын Их Хурлын хяналт, шалгалтын байдалд шүүмжлэлтэй хандаж, хяналтын талаарх ойлголт, чадавхи сул байгааг тэмдэглэсээр ирсэн. Тухайлбал, “...мэдээ тайлан сонсох, асуулт тавихаас өөр тогтмол механизм бараг байхгүй байна”²⁵ гэж үздэг. Өөрөөр хэлбэл парламентын хяналтын үр нөлөөг дээшлүүлэх, арга механизмыг улам боловсронгуй болгох, парламентын автономи байдлыг хангах асуудал чухлаар тавигдсаар байна.

²⁴ О.Машбат “Үндсэн хууль: улс төр-эрх зүй, хяналт-тэнцэл” УБ., 2015, 161 дэх тал

²⁵ “Монгол улсад Ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: дүн шинжилгээ” УБ., 2015, 33 дахь тал

Монголд парламентын хяналтыг сайжруулах ямар арга зам байна вэ?

Манайд парламентын хяналтыг хэрэгжүүлэх улс төрийн сонирхол, санаачилга хангалтгүй, хэлбэр төдий байгаа нь парламентад суудалтай улс төрийн хүчнүүдийн бодлого, үйл ажиллагаа, намын лидерүүдийн идэвхи, оролцоо, улс төрийн соёл, иргэд олон нийтийн оролцоо дутмаг гэх зэрэг хүчин зүйлээс хамаарч байна. Тухайлбал, Улсын Их Хуралд аль нэг улс төрийн хүчин олонхи болж дангаар Засгийн газрыг бүрдүүлэн ажиллахдаа УИХ-ын гишүүний болон Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүний албыг давхар хаших, ингэхдээ ялсан намын дарга Ерөнхий сайд, тухайн намын бусад лидерүүд Засгийн газарт орж ажиллан парламент дахь намын бүлгээрээ уламжлан Улсын Их Хурал, олонхийн гишүүдийг хяналтдаа байлгаж, улмаар парламентын хяналтыг хэлбэр төдий байлгах улс төрийн нөхцөл манайд байсаар байна. Ийм нөхцөлд “Сөрөг хүчин”-ий үйл ажиллагаа, бодлогоос ихээхэн зүйл хамаарна.

Улсын Их Хурлын стратеги, төлөвлөгөөнд туссан үндсэн зорилтод парламентын хянан шалгах, үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, түүний үр нөлөөг дээшлүүлнэ гэж заасан байдаг. Энэ хүрээнд дараах асуудлыг дэвшүүлэн тавьж байна. Үүнд:

- **Парламент, түүний гишүүдийг хариуцлагажуулах:** Парламентын хяналтыг ашиглах улс төрийн нам, улс төрчдийн хүсэл зоригийг төрүүлэх нь хамгаас чухал. Үүний тулд Улсын Их Хурал өөрөө сахилга баттай байж, парламентад ёс, улс төрийн соёлыг төлөвшүүлэх, Улсын Их Хурлын гишүүдэд хяналтын чиг үүргийн ач холбогдлыг тайлбарлан таниулах шаардлага тулгараад байна.
- **“Сөрөг хүчин” буюу цөөнхөд хяналтын давуу эрх олгох:** Цөөнхийн эрхийг хүндэтгэх, тэдний байр суурийг бэхжүүлж, хэрэгжүүлдэг тогтолцоо төлөвшүүлэх шаардлагатай. Парламентад олонхи болсон улс төрийн хүчин ихэнхидээ гүйцэтгэх засаглалыг толгойлсон намын дарга, лидерүүддээ сахилга баттайгаар захирагддаг бөгөөд ийм тохиолдолд парламентын хяналт сулрах, идэвхигүй, хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх сонирхолгүй байх нь ажиглагддаг. Иймд парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд сөрөг хүчний оролцоо, боломжийг нэмэгдүүлэх нь ач холбогдол өндөртэй юм. Тухайлбал, ХБНГУ-ын Гамбург мужийн Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн “А” дахь хэсэгт дараах хоёр заалтыг оруулжээ. Үүнд:
 - ✓ Парламентад ёсны салшгүй нэг чухал хэсэг нь сөрөг хүчин мөн
 - ✓ Сөрөг хүчин нь Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг үндсэн асуудлаар шүүмжлэх, зарим талаар олон нийтийг төлөөлөх байнгын үүрэг, зорилттой байна²⁶ гэжээ.

Мөн “Сүүдрийн Засгийн газар” хэмээх ойлголтыг энд багтаан ойлгох хэрэгтэй. Энэ нь улс төрийн бодлого боловсруулж ард түмэнд хүргэхийн тулд “Сөрөг хүчин”-ий байгуулдаг институт юм. Тухайлбал, Англид сөрөг хүчний хамгийн том намын дарга нь сүүдрийн Ерөнхий сайд болж тус намаас парламентад сонгогдсон гишүүдээс “Сүүдрийн Засгийн газар”-ыг бүрдүүлж, эрх барих хүчний байгуулсан албан ёсны Засгийн газрын бодлоготой санал нийлэхгүй асуудлуудын талаар өөрсдийн байр суурийг илэрхийлж, бодлого боловсруулан ажилладаг байна. Англид ийм институтдээ зориулж төсөв баталж, тусгай өрөө тасалгаагаар хангадаг²⁷ ажээ.

- **Хяналтын үйл ажиллагаанд “Олон нийтийн оролцоо”-г хангах:** Иргэд олон нийтэд парламентын хяналтын ач холбогдлыг сурталчлан таниулах, тэдний дэмжлэгийг авах нь туйлаас чухал. Олон нийтийн санал бодолд тулгуурлан Засгийн газрын бодлого үйл ажиллагааг хэлэлцэн хяналтыг явуулах нь гүйцэтгэх эрх мэдэлд ил тод, нээлттэй байдлыг бий болгоно. Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөнд парламентын

²⁶ Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан “Парламентад ёс” УБ., 2005, 88 дахь тал

²⁷ [mn.wikipedia.org > wiki > : “Сүүдрийн Засгийн газар”](http://mn.wikipedia.org/wiki/Сүүдрийн_Засгийн_газар)

хяналтыг сайжруулах урт хугацааны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “...Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хяналтын үйл ажиллагааг илүү ил тод, нээлттэй болгох”²⁸ тодорхой заалтууд туссан байгаа нь сайшаалтай. Мөн энэ хүрээнд “Нээлттэй сонсгол”-ыг парламентын хяналтад түлхүү ашиглах нь чухал ач холбогдолтой. Манайд “Нийтийн нээлттэй сонсголын тухай хууль” батлагдсан байгаа боловч туйлын чамлахаар хэрэгжилттэй байна.

- **Парламентын “Мөрдөн шалгах” эрх:** Парламент өөртөө мэдээлэл олж авах хамгийн хүчтэй хэрэгсэл болдгоороо онцлогтой. Энэ нь тодорхой асуудал дээр илүү гүнзгий дүн шинжилгээ хийхэд зориулагддаг бөгөөд нийгмийн ач холбогдол бүхий маргааныг талууд хамтран сонсож, мэдээлэл аван, шийдвэр гаргахад үйл ажиллагаагаа чиглүүлдэг. Макс Вебер “Парламентын гишүүд бол мэдээллийг бүрэн авч байх эрхтэй ард түмний төлөөлөгчид. Гэвч бодит байдал дээр Засгийн газар тэдэнд мэдээллийг бүрэн өгдөггүй. Гэрчийг сонсож, нотлох баримт цуглуулах эрх бүхий парламентын мөрдөн шалгах хороог байгуулах нь гишүүд эрхээ эдлэх чухал механизм юм”²⁹ гэж үзсэн байдаг. Судлаачид мөрдөн шалгах эрх мэдлийг Ерөнхийлөгчийн засаглалтай улсад байнгын хороонд, парламентын засаглалтай үед цөөнхөд эрхийг нь өгвөл илүү үр дүнтэй гэж үздэг байна. Парламентын мөрдөн шалгах эрх мэдэлд хоёр үндсэн загвар байдаг.³⁰
 - АНУ-ын загвар. Байнгын хорооддоо голчлон түшиглэдэг
 - ХБНГУ-ын загвар. Цөөнхийн эрхэд үндэслэн, парламентын нэгдсэн чуулганаас эрх мэдэл авсан түр хороогоор дамжуулан хэрэгжүүлдэг.

Дүгнэлт

Хууль тогтоох эрх мэдлийн салшгүй нэг хэсэг нь парламентын хяналтын асуудал бөгөөд төрийн эрх мэдэл хуваарилах онолын харилцан хяналтын зарчимд нийцэж буй юм. Ардчилсан Үндсэн хуульт улс бүрийн парламентад энэхүү хяналтын асуудлыг онцгойлон үздэг. Өөрөөр хэлбэл, парламентын автономи байдал хангагдаж, гүйцэтгэх засаглалаас хараат бус байх нөхцөл бүрдэнэ. Парламент нь нэгдүгээрт нийт ард түмний төлөөлөл, хоёрдугаарт хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг тул нийт ард түмнийг төлөөлөн Засгийн газрын үйл ажиллагаа, бодлого, хуулийн хэрэгжилтэд дээд хяналт тавих нь зүй ёсны асуудал бөгөөд парламентын хяналтын үзэл санааны үндэс эндээс харагддаг. Өөрөөр хэлбэл, ард түмний төлөөлүүлсэн эрх мэдлийг парламент л хэрэгжүүлдэг.

Судлаачид парламентын хяналтыг институтэжсэн, мэргэжлийн хэлбэрээр зохион байгуулах нь илүү үр дүнтэйг тэмдэглэсэн байдаг. Энэ ч утгаараа Монголд парламентын институтэжсэн хэлбэр, хороодын хяналтыг сайжруулах, арга механизм, цөөнхийн эрхийг хамгаалах асуудал чухлаар тавигдаж байна. Мөн парламентын хяналтын хэрэгслүүдийн хувьд улс орнуудыг харьцуулж үзэхэд засаглалын хэлбэрээрээ парламентын засаглал бүхий улсуудынх, орлогын түвшингээр нь үзэхэд дундаж улсуудынх илүү, ардчиллын түвшингээр нь авч үзвэл ардчилсан байх тусмаа илүү олон янзын хяналтын арга хэрэгсэлтэй байгаа нь харагдсан. Харин манай улсын хувьд эдгээр үзүүлэлтээр дундаж түвшинд байгаа боловч Улсын Их Хурлын хяналтын арга, хэрэгслийг судлаачид хэлбэр төдий, асуух, сонсохоос хэтрэхгүй, парламент өөрөө хяналтаа хэрэгжүүлэх сонирхолгүй байдаг зэрэгтэй холбон үздэгийг дурдах нь зүйтэй.

Монголд парламентын хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн боловч түүнийг хэрэгжүүлэх сонирхол дутмаг, нарийн зохицуулсан

²⁸ УИХ-ын Тамгын газрын судалгааны төв “Бодлогын судалгаа, шинжилгээ” XII боть УБ., 2012

²⁹ www.niidelch.mn Х.Тэмүүжин “Парламентын мөрдөн шалгах эрх мэдэл” өгүүлэл, 2014

³⁰ Мөн тэнд

арга, механизм байхгүй, хамгийн гол нь сөрөг хүчний энэ чиглэлийн үйл ажиллагааг дэмжсэн хөшүүрэг, зохицуулалт туйлын хангалтгүй байсаар байна. Мөн парламентад олонхын суудал авсан улс төрийн хүчин, намын бодлого, үйл ажиллагаа ихээр нөлөөлж байгаа юм. Сөрөг хүчинд хяналтын чиг үүргийг давуу байдалтай олгох, олон нийтийн оролцоо, дэмжлэгийг авах улс төрийн болон эрх зүйн орчныг сайжруулах зайлшгүй шаардлага тулгараад байна. Мөн парламентыг өөрийг нь хариуцлагажуулах, хяналтыг хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний дэмжлэгийг авах, “нээлтэй сонсгол”-ыг тогтмолжуулах, ил тод, нээлтэй байдлыг хангах нь туйлаас чухал. Эцсийн дүндээ Засгийн газрын үйл ажиллагааг хянах, залан чиглүүлэх, хариуцлага тооцох үндсэн арга механизм бол парламентын хяналтыг хэрэгжүүлэх явдал бөгөөд шударга, ил тод, нээлтэй, хариуцлагатай Ардчилсан төрийн үндсийг бүрдүүлэхэд чухал хөшүүрэг болох юм.

Abstract: One of the legislative power or its significant element is a parliamentary oversight issue and the implementation is being implemented in various methods or forms depending on the state governance form, economic, and democracy index. Monitoring an institution for executive power from parliament is based on a mutual monitoring principle for the theory of sovereignty and conformed with them. Therefore, the research paper has determined the current state of parliamentary oversight in Mongolia, the implementation forms, and readjustments as well as studied a legal framework for implementation, potential, and the political state. Improving the parliamentary oversight effects and accomplishing the methods or the mechanism is to be significant results for the parliamentary autonomy and the parliamentary democracy. Key words: legislative power, parliament, oversight, monitoring, and opposition

Ашигласан материал

1. Ж.Төртогтох “Үндсэн хуулийн политологийн шинжилгээ” УБ., 2010
1. Д.Лүндээжанцан “Эрх мэдэл ба Ардчилал” УБ., 2015
2. П.Амаржаргал “Үндсэн хуулийн эрх зүй, Парламентын онол үзэл баримтлалын асуудал” эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл., 2015
3. Ж.Төртогтох “Парламент судлалын гарын авлага” УБ., 2010
4. О.Машбат “Үндсэн хууль: улс төр-эрх зүй, хянал-тэнцэл” УБ., 2015
5. Д.Болд-Эрдэнэ “Улс төрийн философи” УБ., 2015
6. Шарль Монтескье “Хуулийн амин сүнс” орчуулга
7. Х.Ганбаатар нарын “Өрнөдийн улс төрийн сэтгэлгээний түүх” УБ., 2009
8. Ч.Энхбаатар, С.Зульфикар “Гадаад орнуудын төрийн байгууламж” УБ., 2014
9. “Шинэ толь” сэтгүүл, Б.Дэлгэрмаа “Парламентын засаглал, хууль тогтоох бүрэн эрх ба УИХ” УБ., 50 дахь тал, 1999
10. Д.Лүндээжанцан “Монгол дахь төрийн эрх мэдэл хуваарилал” УБ., 2001
11. Б.Чимид “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх нь” илтгэл, 2010
12. Улсын Их Хурлын Тамгын газар “Бодлогын судалгаа, шинжилгээ” XII боть, УБ., 2012
13. Х.Номингэрэл “Парламентын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх механизм, бусад орнуудын жишиг, Монгол Улсын Их Хурлын хяналтын чиг үүргийг боловсронгуй болгох асуудал” ,“Байнгын ажиллагаатай Парламент 25 жил” ЭШХЭ УБ., 2015
14. Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар “Монгол улсын Үндсэн хуулийн эрх зүй”, 2000
15. www.niitlech.mn Х.Тэмүүжин “Парламентын мөрдөн шалгах эрх мэдэл” өгүүлэл, 2014
16. Монгол Улсын Үндсэн хууль., 1992

17. Hironori Yamamoto "Tools of parliamentary oversight" Switzerland., 2007 /IPU/
18. Ricardo Pelizzo and Rick Stapenhurst "Tools for Legislative Oversight: An Empirical Investigation" 2000